

**УИХ-ын сонгуулийн олонхи/дийлэнхийн
тогтолцоог боловсронгуй болгох нь**

Бодлогын зөвлөмж

АГУУЛГА

Удиртгал

I Хэсэг. Асуудлын үндэслэгээ: УИХ-ын сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох үндэслэл, шаардлага

1.1 Практик шаардлага

1.2 Хууль зүйн шаардлага

1.3 Нийгмийн сэтгэлзүйн шаардлага

II Хэсэг. Мажоритар тогтолцоо, түүний онцлог

2.1 Олонхи/дийлэнхийн тогтолцооны онцлог, гол давуу талууд

2.2 Олонхи/дийлэнхийн тогтолцооны үндсэн хувилбарууд

III Хэсэг. Бодлогын сонголтууд: Дөрвөн хувилбар – харьцуулсан үнэлгээ

3.1 Дэлхийн улсуудад хэрэглэгдэх хүрээ

3.2 Улс төрийн дэглэмийн шинж чанарт хэрхэн нөлөөлөх

3.3 Улс төрийн намын системд хэрхэн нөлөөлөх

3.4 Улс төрийн системийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөх

3.5 Сонгогчдын төлөөллийг хэрхэн тусгах

3.6 Сонгогчдод хэр ойлгомжтой хялбар байх

3.7 Сонгуулийг уг хувилбараар явуулахад гарах өртөг зардал

3.8 Сонгогчдын идэвх, оролцоонд хэрхэн нөлөөлөх

IV Хэсэг. Дүгнэлт ба зөвлөмж

Хавсралт

Лавлагаа

Удиртгал

1990 оны анхны ардчилсан сонгуулиас хойш Монгол улс дахь сонгуулийн тогтолцоо орчин үеийн жишиг, Монгол дахь улс төрийн амьдралын өвөрмөц онцлогийг тусган хөгжөөд багагүй хугацаа өнгөрлөө. Гэхдээ сонгуулийн өнөөгийн тогтолцоо, түүний эрх зүйн үндэс болсон хууль нь улс төр, нийгмийн өөрчлөлт, ардчилсан зарчмуудад нийцэхгүй байгаагаас ардчилсан нийгэм дэх сонгуулийн үүрэг нөлөө багасч, иргэдийн сонгуульд хандах хандлага, үнэлэмж буурч байна. Тиймээс сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох нь өнөөгийн төрийн бодлогын зайлшгүй шийдвэл зохих асуудлын нэг болоод байна.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь сонгуулийн олонхи/дийлэнхийн (цаашид ОД гэх) тогтолцоо манай улсад тохирох эсэхийг өнгөрсөн 12 жилийн туршлагаас судлан дүгнэх, ОД тогтолцооны хувилбаруудыг судлаж ажлын хэсэгт мэдээлэл, зөвлөмж өгөхөд оршино. Үүнтэй уялдан дараахи зорилтууд тавигдсан юм. Үүнд:

- УИХ-ын сонгуульд ОД тогтолцоо, ялангуяа 1 мандаттай тойрог бүхий харьцангй олонхийн хувилбарыг эсэргүүцэж буй шүүмжийг нягтлан үзэх
- Сонгуулийн тогтолцооноос намын систем болон засаглалд үзүүлэх нөлөөллийн талаархи онолын бүтээлүүдийг харьцуулах
- Дээрх судалгаанд тулгуурлан сонгуулийн ОД тогтолцооны ямар хувилбарыг нутагшуулбал манай улсад зохистой байх тухайд дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг болно.

Сүүлийн үед сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох талаархи санал, хэлэлцүүлгийн нилээд нь өдгөө хэрэглэж буй мажоритар тогтолцоог өөрчилж хоимог эсхүл пропорционалоор солиход чиглэж байгаа билээ. Гэвч сонгуулийн тогтолцоогоо ийнхүү өөрчлөхийн өмнө одоогийн тогтолцоогоо эргэн харах, үнэхээр өөрчлөх үндэслэл бий эсэхийг тогтоох нь үүсч болох хөрөнгө санхүү, улс төр, нийгмийн бусад

эрсдэлээс хамгаалах учиртай. Ер нь сонгуулийн тогтолцоогоо байнга өөрчлөх улс төрийн маш том эрсдэл дагуулж байдгийг анхаарч үзэх хэрэгтэй юм. Тийм учраас бид судалгааны явцад улс төрийн намууд болон судлаачдын дунд маргаантай байгаа дараахи асуудлуудад хариулт өгөхийг зорьсон юм. Үүнд:

- УИХ-ын сонгуульд өдгөө хэрэглэж буй ОД нь сөрөг үр дагавар ихтэй муу тогтолцоо юу?
- Эсвэл бид энэ системийг буруу хэрэглээд байна уу?
- Дэлхийн ардчилсан дэглэм бүхий улсуудын тэн хагас нь яагаад энэ тогтолцоог хэрэглээд байна вэ?
- Монголын сонгуулийн тогтолцоог бүрэн сольж эрсдэл хийхгүйгээр өнөөгийн тогтолцоогоо засч сайжруулах арга байна уу?

Эдгээр асуудлыг тодорхой болгохын тулд ОД тогтолцоо бүхий дэлхийн улс орнуудыг харьцуулан судалж, Монголдахь мажоритар тогтолцооны бодит хэрэгжилтийг шүүн тунгааж, энэ тогтолцооны улс төрийн болон намын системд үзлэх нөлөөллийг авч үзлээ.

I Хэсэг. Асуудлын үндэслэгээ: УИХ-ын сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох үндэслэл, шаардлага

Сонгуулийн систем бүрэлдэн тогтсон нь

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн систем ямар байвал зохих тухай маргаан 1992 онд анхны сонгуулийн хуулийг батлан гаргаж байх үеэс өнөөг хүртэл тасралтгүй өрнөж байгаа юм.

Манай улс ардчилалд шилжин орсон 12 жилийн хугацаанд ОД системийн дөрвөн хувилбараас хоёрыг нь хэрэглэж ирсэн. 1992 оны УИХ-ын сонгууль олон мандаттай, томсгосон тойрог гэж бидний нэрлэдэг *block vote* системээр явагдсан юм. Энэ сонгууль тэгш эрхийн зарчмыг зөрчсөн дутагдалтай болсон гэж улс төрчид судлаачид үзсэн бөгөөд 1995 онд сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, ОД-ийн системийн сонгодог хувилбар болох 1 мандаттай харьцангуй олонхийн систем рүү шилжсэн юм. Сонгуулийн хууль 1995 оноос хойш өөрчлөгдөөгүй бөгөөд 1996, 2000, 2004 оны сонгууль эл хуулиар явж ирсэн байна.

Сонгуулийн системийн зүгээс намын системд үзүүлсэн нөлөө

Сонгуулийн систем нь намын систем бүрэлдэн тогтоход зонхилох хүчин зүйл болдог тухай олон судлаачид тэмдэглэсэн байдаг. ОД систем нь төвлөрсөн хоёр намын системийг бүрдүүлдэг, харин хувь тэнцүүлсэн систем нь харилцан тэнцвэртэй олон намын системийг бүрэлдүүлдэг түгээмэл хандлага бий.

УИХ-ын сонгуулийн ОД систем нь манай улсад ч хоёр намын систем тогтох шууд хүчин зүйл болж байна. Эл хоёр нам, хүчин хоёул засгийн газар байгуулж, гүйцэтгэх эрх мэдэлд ажиллаж үзсэн туршлагатай төлөвшиж буй хүчнүүд юм. Хоёр намын системд манай улс төрийн тогтолцоонд бодит байдал болоод зогсохгүй улс төрийн соёл болон төлөвшиж байгаа юм.

ОД системд тулгуурласан хоёр намын систем бүхий парламентын засаглал Их Британи болон түүний колони байхдаа улс төрийн соёлыг

нь уламжилж авсан Канад, Австрали, Шинэ Зеланд болон АНУ-д тогтсон байдаг.

Сонгуулийн систем ба орон нутгийн харилцаа

Манай улсад хэрэглэж буй 1 мандаттай тойрог бүхий системийг улс төрчдөд жалга довны үзэлд уягдсан хэмээн шүүмжлэх хандлага нийтлэг байдаг. Энэ хандлага улсын төсөв хэлэлцэх үеэр ихээхэн ажиглагддаг юм.

Сонгуулийн кампанийн үеэр ч нэр дэвшигчид тойргийн хүн амд зориулсан явцуу амлалт авч, эрх мэдлийн хуваарийн дагуу засаг даргын хийх ёстой ажлыг, тухайлбал хорооллын дотор зам тавих, сумд өндөр хүчдэл татах зэргийг амлах, гүйцэтгэх явдал газар авч байгаа нь сонгуулийн ОД системтэй шууд холбоотой юм.

Гэтэл нөгөө талаас энэ нь давуу тал юм. Хэрэв УИХ-ын сонгуульд намын нэрээр санал хураах хувь тэнцүүлсэн системийг хэрэглэсэн бол улс төрчид зөвхөн Улаанбаатар хотод төвлөрч, хөдөө орон нутаг улс төрийн тэмцлийн талбарын гадна атаршиж үлдэх байсан билээ.

Парламентийн засаглалд үзүүлсэн нөлөө

Сонгуулийн нэг мандаттай олонхийн системийн шууд үр дүнд парламентад үнэмлэхүй олонхи, хэт цөөнх үүсэх хандлагатай байдаг. Үнэмлэхүй олонхи парламентад бий болсноор ялсан намын даргын гарт хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл төвлөрөх хандлага бий. Үүнийг *winner takes all* буюу *ялсан нь бүгдийг нь авна* гэдэг юм. Нэг нам давамгайлсан парламентын гол давуу тал болох тогтвортой засгийн газрууд манайд удаа дараа бүрдэж ирсэн нь сонгуулийн системтэй холбоотой юм.

Намын жагсаалтаар санал хураалт явагддаг цэвэр пропорциональ системд хэт олон жижиг нам парламентыг бүрдүүлж, хоорондоо зөвшилцөж чадаагүй сургамж дэлхийн улсуудад байдаг. Италид 1945 оноос хойш 1992 оныг хүртэл 47 жилийн дотор нийт 50 засгийн газар

байгууоогдан огцорч байсан билээ. [Andrew Reynolds 1997: 174] Өөрөөр хэлбэл, жилд дор хаяж нэг удаа засгийн газар солигдож байжээ.

Гэтэл ОД системийн дүнд бүрэлдсэн парламентын үнэмлэхүй олонхи засгийн газраа дэмжин ажилладаг онцлогтой. Энэ нь гүйцэтгэх эрх мэдлийн тогтвортой байдлын баталгаа болдог юм.

Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох үндэслэл

Өдгөө энэ тогтолцоо, түүнд үндэслэн боловсруулсан сонгуулийн хуулийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч буйг бид дараахи байдлаар тодорхойлж байна.

1.1 Практик шаарлага

1992 онд батлагсан УИХ-ын сонгуулийн хуулийн дагуу явагдсан 1992 оны олон мандаттай, томсгосон тойргоор сонгуулийг явуулсан нь сонгуулийн тэгш эрхийн зарчмыг ноцтой зөрчсөн, мөн сонгуулийн дүнг гаргахад ч бэрхшээлтэй асуудлуудыг ч үүсгэж байсан.

1996 оны 1-р сард уг хуульд нэмэлт өөрчлөлт УИХ оруулж ийнхүү 1996, 2000, 2004 оны УИХ-ын сонгуулиуд нэг мандаттай, олонхийн хувилбараар явагдаж ирсэн. Энэ хувилбараар явагдсан сонгуулиудад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах нийтлэг сул тал, дутагдлууд ажиглагдан байна. Үүнд:

- Эрх баригчид болон улс төрийн хүчнүүд сонгуулийн үйл явцад үзүүлэх сөрөг нөлөөлөл, ялангуяа сонгууль дөхсөн үед өөрт ашигтайгаар сонгуулийн хуулийг тайлбарладаг, хэрэглэдэг боломж их байна.
- Сонгуулийн дүнгээр сонгогчдоос авсан санал, парламентад авсан суудлын тооны зөрүү их байна.
- Сонгуульд оролцох иргэдийн, идэвх буурч байна.
- Сонгуулийн кампаны санхүүжилт ил тод бус, хяналтгүй учраас мөнгө сонгуулийн үр дүнд шийдвэрлэх нөлөө үзүүлж байна.
- Сонгуулийн хороодын үйл ажиллагаа, удирдлага, зохион багуулалт нь бие даасан, хараат бус байж чадахгүй байна.

- Төрийн эрх мэдэл, өмч, унаа, албан хаагч, мээдээллийг сонгууль, сонгуулийн кампаны өмчид ашиглах явдал их байна. [Нээлттэй Нийгэм Форум, 2004]
- Сонгуулийн хуульд хоёрдмол утгаар ойлгож болох зүйл заалт нилээдгүй тусгагдсан, мөн зарим асуудлыг нарийн тодорхой хуульчлан зохицуулаагүйгээс болж болж зарим заалтыг ташаа ойлгож хэрэглэх, гуйвуулан тайлбарлах, үүнийг сонгуулийн булхайд ашиглах явдал их байна.
- Сонгуулийн хууль тогтоомжид хариуцлагын механизм тодорхой нарийн хуульчлагдаагүйгээс хариуцлага хүлээдэг, тооцдог механизм алга байна.

1.2 Хууль зүйн шаардлага

- 2002, 2003 онд УИХ-аас баталсан зарим хөтөлбөр, баримт бичгүүдэд сонгуулийн удирдлага, зохион байгуулалт, сонгох сонгогдох эрхийг хангах талаар нэлээд нарийвчилсан зохицуулалт хийхээр тус тус заасан бөгөөд түүнийг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. [Сонгогчдын боловсрол төв, 2004]

Тухайлан дурьдвал:

- 2003 оны 10-р сарын 24-ний өдөр байгуулагдсан Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт:

2.2.1.1 Сонгуулийн тогтолцоо, үйл явцын журмыг иргэдийн бие даасан оролцоог хангаж чадварлаг УИХ бүрдүүлэх болон төлөөлөх ардчилалыг хөгжүүлэхэд чиглүүлж боловсронгуй болгоно.

2.2.1.6 Сонгуулийн ерөнхий хороо болон тойрог хэсгийн хороодын гишүүний бүрэлдэхүүнд сонгуульд оролцогч аль нэг нам, эвслийн төлөөлөл давамгайлахыг хязгаарлана.

2.2.1.7 Сонгогч нь сонгуульд нэр дэвшигч, сонгогдогчийн үйл ажиллагааны талаар аливаа мэдээлэл авах эрхийг баталгаажуулан хангана.

2.2.2.3 Төрийн жинхэнэ албан хаагчидыг улс төрийн үйл ажиллагаанаас зааглах хэмээн заасныг хэрэгжүүлэх

- 2002 оны 7-р сарын 4-ний өдөр батлагдсан Монгол улсын авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрт :

1. Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

А. Авилгалтай холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг аливаа сонгуульд нэр дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохыг хориглох

Б. Сонгуульд оролцох улс төрийн намууд сонгуулийн зардал хандивын талаар сонгууль болохоос өмнө сонгуулийн ерөнхий хороонд танилцуулж нийтэд мэдээлэх журам тогтоох

В. Иргэн хуулийн этгээдээс сонгуулийн сурталчилгаанд өгч байгаа хандивын хэмжээд хязгаар тавих гэж заасныг хэрэгжүүлэх.

- 2003 оны 09 сарын 10-11ний өдөр Улаанбаатар хотноо хуралдсан

Ардчилалыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлын баримт бичгүүдэд зааснаар оролцогч засгийн газрууд өөрийн орондоо сонгуулийн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сонгуулийн бүхий л зарчмуудыг баталгаажуулан хамгаалсан арга хэмжээ авах, чөлөөт шударга сонгуулийн механизмыг бий болгох, түүнийг ардчилсан сонгуулийн жишигт нийцүүлэх үүргийг хүлээсэн бөгөөд түүнийг хэрэгжүүлэх шаардлага мөн тус улсад ч тулгарч байна. [Сонгогчдын боловсрол төв, 2004]

1.3 Ниймийн сэтгэл зүйн шаардлага

- Жил ирэх тусам иргэдийн сонгуульд оролцох оролцоо буурч байгаа нь цаашид тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээтэйг илэрхийлж байна.
- Сонгуулийн үеээрх олон тооны маргаан, булхай, будилаанаас болж сонгогчдын зүгээс сонгуулийн ач холбогдолыг үл ойшоох, цаашлаад төрийн легитим шинж буурах сөрөг талууд ажиглагдаж байна.
- Сонгуульд нэр дэвшигчдийн санхүүжилтэд тавих хяналт байхгүйгээс болж жил ирэх тусам сонгуулийн зардал өсөх, нэр дэвшигчид мөнгө санхүүгийн хүчин зүйлээр сонгогчдыг татах явдал газар авч байна. Улмаар сонгогчдын дунд мөнгөтэй хүнийг сонгох, санхүүгийн ашиг хонжоо олох гэсэн хандлага нийтлэг болсон нь ардчилсан сонгуулийн шинж чанрыг алдагдуулах боллоо.

II Хэсэг

Олонхи/дийлэнхийн тогтолцоо, түүний онцлог

2.1 Олонхи/дийлэнхийн тогтолцоо, түүний гол давуу талууд

Олонхи/дийлэнхийн тогтолцоо нь онолын хувьд англо-саксоны систем гэж тооцогдох бөгөөд ардчиллын олонхийн загварт хамаарах юм. Үүнийг мөн Вестминстерийн загвар ч гэж нэрлэдэг. Гол онцлог нь өрсөлдөөнөөс илүү зөвшилцөл, нэгдмэл байдлыг дээдлэх явдал юм.

А. Улс төрийн хоёр хүчин төлөвшин тогтворжих суурь нөхцөл болдог. Сонгогчид ихэвчлэн улс төрийн хоёр гол нам, эвсэлийн аль нэгийг сонгох болдог ба гуравдагч намуудын хувьд олонхий санал авах боломж нэн хязгаарлагдмал байдаг.

Б. Парламентад нэг нам олонхи болох буюу нэг намын засгийн газар байгуулагдан ажиллах боломж маш өндөр байдаг. Эвслийн засгийн газар байгуулагдах тохиолдол байдаг ч төдийлөн түгээмэл биш. Энэ нь засгийн газрын тогтвортой үйл ажиллагаа, хариуцлагыг дээшлүүлэх сайн талтай.

В. Хүчтэй сөрөг хүчин бүрэлдэх боломжийг нээж өгдөг. Парламентад олонхи болсон нам ба сөрөг хүчин гэсэн хоёр хүчин бие биеийг хянах боломжийг илүүтэй болгодог.

Г. Өргөн олон нийтэд тулгуурласан буюу нийт улс орны хэмжээний намууд төлөвшин хөгжихөд түлхэц өгдөг. Ялангуяа энэ нь үндэстэн, угсаатны ихээхэн ялгарал бүхий нийгэмд хүн амын олонхи цөөнхийг аль алиныг нь төлөөлж байж амжилт олох боломжтой байдаг.

Д. Энэ тогтолцооны үед санал өгөх, санал тоолох, сонгуулийн дүн гаргах, ялагчийг тодорхойлох зэрэг нь ойлгомжтой энгийн байдаг. Сонгогчид нэр дэвшигчидийн жагсаалтаас өөрийн сонгож буй хүнийг онцлон тэмдэглэж, энэ нь саналыг тоолох ажиллагааг ч энгийн хялбар болгодог.

Е. Энэ тогтолцоо нь экстремист намуудад маш халгаатай буюу парламентаас тэдгээрийг шахан гаргадаг. Экстремист намууд улс орны тодорхой бүс нутаг, үндэсний цөөнхийг төлөөлж байдаг тул энэ тогтолцооны үед нийт улс орон даяар олонхийн дэмжлэг авах боломж үндсэндээ байдаггүй.

Ё. Парламентийн гишүүн болон түүний сонгогдсон тойргийн сонгогчидын хооронд тогтвортой холбоо, хариуцлагын тогтолцоог бий болгодог. Энэ тогтолцооны үед парламентийн гишүүн нь зөвхөн улс төрийн намыг төлөөлөх бус харин өөрийн сонгогдсон тойргийн иргэдийг мөн төлөөлөх болдог. Тухайн гишүүн аль нэгэн тойргоос сонгогдохын тулд тэр тойргийн иргэдийн эрх ашиг, шаардлагыг парламентад уламжлах, хэрэгжүүлэх хариуцлага хүлээдэг. Мөн дараа дараагийн сонгуульд сонгогдох боломж нь ч энэ үйл ажиллагаагаар нь тодорхойлогдох нь олонтаа ажиглагддаг. Зарим судлаачид гишүүн-сонгогчидийн ийм тогтвортой холбоо хамаарал нь эдийн засагт хөдөө аж ахуй давамгайлсан болон хөгжиж буй улс орнуудад чухал ач холбогдолтой гэж үздэг.[Andrew Reynolds, 1997: 83]


Ж. Пропорциональ тогтолцоо, ялангуяа нэр дэвшигчийн жагсаалт бүхий пропорциональ тогтолцооны үед сонгогчид зөвхөн намуудын дэвшүүлж буй хүмүүсийн нэрсээс бус тодорхой тухайн сонгогчидод хандсан тодорхой мөрийн хөтөлбөр бүхий, бие хүмүүсээс сонголт хийх боломж сонгогчдод олгодог.

З. Олон түмэнд танигдсан бие даан нэр дэвшигчид сонгогдох боломж бусад тогтолцоотой харьцуулахад харьцангуй өндөр байдаг буюу зөвхөн намд төвлөрсөн улс төрийн тогтолцоог даван туулах боломжийг хувь хүмүүст олгодог.

2.2 Олонхи/дийлэнхийн тогтолцооны үндсэн хувилбарууд

Сонгуулийн ОД тогтолцоог сонгох тохиолдолд энэ системийн дөрвөн үндсэн хувилбараас хэрэглэх боломжтой юм.

Эдгээрийг дараахи байдлаар хүснэгтээс үзэж болно.



Бид дээрх хүснэгтээс ОД системийг маш товчоор тайлбарлая.

ОД систем нь үндсэн дөрвөн хувилбартай байдаг ба эдгээр нь:

А. First Past The Post буюу 1 мандаттай харьцангй олонхийн хувилбар. Энэ нь одоогийн УИХ-ын сонгуулийн тогтолцоо юм.

Б. Block Voting буюу томсгосон тойргийн тогтолцоо. Ийм тогтолцоог 1992 оны УИХ-ын сонгуульд хэрэглэж байсан бөгөөд нэг тойрог хэд хэдэн мандат байдаг. Үүнийг мөн олон мандаттай олонхийн систем гэж нэрлэдэг.

В. Alternative voting буюу альтернатив саналын тогтолцоо. Энэ тогтолцоонд нэг тойрог, нэг мандатын зарчим үйлчилдэг. Сонгогч хоёр санал өгөх боломжтой байдаг. Түүний эхний санал нь хамгийн их буюу түрүүнд дэмжиж буй нэр дэвшигчид өгөх санал, харин хоёр дахь нь сонгочийн удаахь ээлжинд дэмжих нэр дэвшигчид өгөх санал болдог. Нэр дэвшигч 50%+1 санал авч байж ялсанд тооцогдоно. Саналыг тоолохдоо эхний саналын дүн 50%+1-д хүрч байвал шууд ялах бөгөөд хүрэхгүй бол хамгийн бага санал авсан нэр дэвшигчид сонгогдын өгсөн хоёр дахь саналыг тоолж бусад нэр дэвшигчдийн санал дээр нэмдэг. Хоёр дахь саналын тоог харгалзан хоёр саналын нийлбэрээс хамгийн их санал авсан нь ялна.

Г. Хоёр шаттай тогтолцоо. Энэ нь нэг тойрог, нэг мандаттай ба нэр дэвшигч 50%+1 хувийн санал авч ялах боломжтой ба хэрэв нэр дэвшигчидийн хэн нь ч ийм санал авч чадахгүй бол эхний шатанд нэр дэвшсэн хүмүүсээс сонгогчидийн 25%-иас дээш санал авсаныг нь хоёр дахь шатны сонгуульд оролцуулж сонгодог.

Хэсэг

Бодлогын сонголтууд: Дөрвөн хувилбар-харьцуулсан үнэлгээ

Төгс төгөлдөр хувилбарыг олох боломжгүй бөгөөд гагцхүү нөхцөл байдалд зохицсон бодлогын хамгийн боломжит хувилбарыг гаргах нь оновчтой юм. Үүний тулд бид ОД системийн олон янз хувилбаруудыг

дараах найман шалгуураар үнэлж Монголын нөхцөлд зохицсон хамгийн үр ашиг бүхий хувилбарыг олохыг зорьсон юм. Үүнд:

1. Дэлхийн улсуудад хэрэглэгдэх хүрээ
2. Улс төрийн дэглэмийн шинж чанарт хэрхэн нөлөөлөх
3. Улс төрийн намын системд хэрхэн нөлөөлөх
4. Улс төрийн системийн тогтворт байдалд хэрхэн нөлөөлөх
5. Сонгогчдын төлөөллийг хэрхэн тусгах
6. Сонгогчдод хэр ойлгомжтой хялбар байх
7. Сонгуулийг уг хувилбараар явуулахад гарах өртөг зардал
8. Сонгогчдын идэвх, оролцоонд хэрхэн нөлөөлөх

Эдгээр шалгуур тус бүрээр ОД системийн хувилбаруудыг харьцуулан авч үзлээ. Үүнийг дор дурьдав.

1. ОД системийн хувилбаруудыг хэрэглэгдэх хүрээгээр нь авч үзье.

Сонгуулийн системийн хувилбаруудаас хамгийн өргөн хэрэглэгддэг систем бол 2000 оны байдлаар дэлхийн 114 улсад ашиглаж байгаа ОД систем юм. Харин хувь тэнцүүлсэн систем болон түүний олон янз хувилбаруудыг дэлхийн 99 улсад хэрэглэж байгаа юм./Хавсралт 3/

ОД системийн хувилбаруудаас хамгийн өргөн тархсан нь АНУ, Их Британи, Канад зэрэг дэлхийн 68 улс, түүний дотор өнөөгийн УИХ-ын сонгуульд хэрэглэж буй нэг мандаттай, харьцангуй олонхийн систем юм. Бүс нутгаар нь авч үзвэл энэ систем Европод төдийлөн дэлгэрээгүй, гол төлөв Ази, Африк болон Номхон далайн орнуудад өргөн тархсан байна./ Хавсралт 2/

ОД системийн томсгосон тойрог бүхий тогтолцоо буюу нь Сингапур, Тайланд, Мальдив, Кувейт, Филиппин, Палестин, Лаос, Бермуд, Фижи зэрэг 13 улсад хэрэглэгддэг төдий л өргөн тархаагүй хувилбар юм.

Альтернатив саналын дийлэнхийн систем нь зөвхөн Австрали, Науру хоёр улсад л хэрэглэдэг харьцангуй ховор хувилбар юм.

Сонгуулийн хамгийн өндөр босготой систем гэж тооцогддог 2 шаттай дийлэнхийн системийг дэлхийн 31 улсад хэрэглэдэг байна. Эдгээр нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Киргизстан, Тажикстан, Узбекистан, Туркменистан, Беларусь, Украин, Молдав зэрэг улсууд мөн Баруун Европоос Франц, Монако бөгөөд бусад нь Иран, Египет, Конго зэрэг Ази, Африкийн улсууд байдаг ажээ./ Хавсралт3-аас үзнэ үү/

2. Улс төрийн дэглэмийн хувьд сонгуулийн системүүд хэрхэн хэрэглэгддэгийг авч үзье.

Олон улсын ардчилал ба сонгуулийг дэмжих хүрээлэн буюу хэмээх сонгуулийн чиглэлээр дагнасан судалгаа хийдэг байгууллагын үнэлгээгээр сүүлийн 20 жилд чөлөөт сонгууль тогтмол явагдаж ирсэн дэлхийн 36 улсын / Хавсралт 5-аас үзнэ үү/ 13 нь ОД системтэй бусад нь холимог болон хувь тэнцүүлэх системтэй байна. Эдгээрээс 9 нь буюу 69,2 % нь нэг мандаттай олонхийн системийг хэрэглэдэг байна. Тэр дундаа дэлхийн хамгийн том ардчилсан улсууд гэж тооцогддог АНУ болон Энэтхэг ийм системтэй юм. Ядуурал, хүн амын өсөлт, нийгэм дэх тэгш бус байдал зэрэг олон бэрхшээлийг туулж буй хэдий ч хагас зууны туршид ардчиллаас эргэж буцаагүй Энэтхэгийн улс төрийн амжилт нь парламентын систем болон сонгуулийн системтэй нь холбоотой юм. Үндэстэн, шашны болон улс төрийн байр суурийн ялгарал ихтэй Энэтхэгийн улс төрийн тогтворт байдалд энэ систем онцгой үүрэг гүйцэтгэдэг ажээ. []

Мөн Freedom House-ийн судалгаагаар 1990 оноос хойш чөлөөт болон хагас чөлөөт ангилалд орж ирсэн 98 улсад хувь тэнцүүлсэн ба нэг мандаттай олонхийн систем зонхилдог байна.

Харин төрийн эрх барих дээд байгууллага нь сонгуулийн замаар бүрэлддэг хэдий ч чөлөөт бус буюу дарангуйлагч дэглэмтэй гэж тооцогддог 46 улсад 2 шаттай дийлэнхийн юмуу олон мандаттай олонхийн тогтолцоог хэрэглэдэг байна.

Хоёр шаттай дийлэнхийн систем нь ардчилсан тогтолцоонд тэр болгон эерэгээр нөлөөлдөггүй нь ийм систем бүхий улсуудын практикаас харагдаж байна. Ялангуяа хуучны коммунист намын нөлөө хүчтэй хэвээр байгаа, улс төрийн шинэ намуудын төлөвшилт сул, ардчилалд шилжиж буй орнуудад сонгуулийн ийм өндөр босго бүхий тогтолцоо нь зонхилох нэг намын дарангуйлал, нийгмийн бүх салбар дахь цөөнхийн хүчтэй хяналтыг бий болгодог нь Украин, Беларусь улсад болж буй парламентын болон ерөнхийлөгчийн сонгууль, түүнийг тойрсон улс төрийн эгзэгтэй нөхцөл байдлаас харагдаж байгаа юм.

Энд нэгэн сонирхолтой зүйл ажиглагдаж байгаа нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан дээрх хоёр улсаас гадна Киргизстан, Тажикстан, Узбекистан, Туркменистан, Молдав зэрэг улсууд 2 шаттай дийлэнхийн системийг сонгож авсан байна. Эдгээр улсууд нь өнөөдөр ардчилал, хүний эрх, эрх чөлөөний түвшингээрээ посткоммунист орнууд дотроо сүүл мушгиж, хагас авторитар дэглэм хэмээн тооцогдож байна.

3. Намын системд нөлөөлөх байдлаар нь ОД системийн хувилбаруудыг авч үзье.

Хувь тэнцүүлэх системийн үед олон намын тогтолцоо, ОД системийн үед хоёр намын юмуу хоёр эвслийн тогтолцоо үүсдэг нь дэлхийн улсуудын ерөнхий жишгээс харагддаг. Сонгогчид ихэвчлэн улс төрийн хоёр гол нам, эвслийн аль нэгийг сонгох болдог ба гуравдагч намуудын хувьд олонхийн санал авах боломж нэн хязгаарлагдмал байдаг. Энэ тогтолцоо нь экстремист намуудад маш халгаатай буюу парламентаас тэдгээрийг шахан гаргадгаараа давуу талтай юм. экстремист намууд улс орны тодорхой бүс нутаг, үндэсний цөөнхийг төлөөлж байдаг тул энэ тогтолцооны үед нийт улс орон даяар олонхийн дэмжлэг авах боломж үндсэндээ байдаггүй.

Тиймээс өргөн олон нийтэд тулгуурласан буюу нийт улс орны хэмжээний намууд төлөвшин хөгжихөд түлхэц өгдөг. Ялангуяа энэ нь үндэстэн, угсаатны ихээхэн ялгарал бүхий нийгэмд хүн амын олонхи цөөнхийн аль алиныг нь төлөөлж байж амжилт олох боломжтой байдаг.

Зөвхөн ОД систем бол хоёр намын тогтолцоог бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл хэмээх тогтсон ойлголтыг няцаах тохиолдол зарим улсуудад гардаг. Хувь тэнцүүлэх тогтолцоотой мөртлөө хоёр намын ба нэг намын систем тогтсон улсууд байдаг. Тухайлбал хувь тэнцүүлэх системтэй мөртлөө 1974-1989 онуудад Грект нэг намын систем тогтож ирсэн байдаг. Мөн холимог системтэй хэдий ч 1949 оноос хойш зүүн, барууны хоёр эвслийн засгийн газар ямагт ээлжлэн засгийн эрх барьж ирсэн ХБНГУ-ыг энд дурьдаж болох юм. тиймээс намын систем яаж төлөвших, хэдэн намын тогтолцоо үүсэх нь тухайн улсын үндэстэн, угсаатны байдал, соёл,шашин, бүс нутгийн ялгаа зэргээс л хамаарна гэж Сартори тэргүүтэй судлаачид үздэг байна. []

4. Улс төрийн тогтворт байдалд хэрхэн нөлөөлдөг эсэхээр нь ОД системийн хувилбарыг авч үзье.

Дэлхийн улсуудын туршлагаас харахад ОД системийн үед парламентад нэг нам олонхи болох буюу нэг намын засгийн газар байгуулагдан ажиллах боломж маш өндөр байдаг. Эвслийн засгийн газар байгуулагдах тохиолдол байдаг ч төдийлөн түгээмэл биш. энэ нь засгийн газрын тогтвортой үйл ажиллагаа , хариуцлагыг дээшлүүлэх сайн талтай.

Альтернатив саналын систем нь сонгуулийн бүх системүүд дотроос улс орны хэмжээнд намуудын интеграци үүсгэдэг, намуудын байр суурийг ойртуулж аядуу тогтолцоо үүсгэдэг онцлогтой юм. Тийм учраас үндэс, угсааны ялгарал ихтэй Папуа Шинэ Гвиней, Фижи зэрэг улсууд үндэсний эв нэгдэл, тогтворт байдал бий болгохын тулд зориудаар энэ системийг сонгож авсан түүхтэй. Монгол улсын хувьд улс төрийн болон нийгэм, үндэсний ялгаа, зөрчил багатай учраас альтернатив тогтолцоог сонгох албагүй ч энэ хувилбар нь сонгогчдын саналыг гээх буюу сонгогчдын өгсөн саналын хувь ба парламент дахь намуудын суудлын тоо зөрөх байдлыг бууруулдгийг санах хэрэгтэй.

Олон мандаттай томсгосон систем нь нэг нам парламентын суудлын үнэмлэхүй олонхийг авч тогтвортой засгийн газар бүрдүүлэх боломж өгдөг хэдий ч эрх баригч намын зүгээс сонгуулийн үр дүнд нөлөөлөх боломжийг өгдөг хэдий ч эрх баригч намын зүгээс сонгуулийн үр дүнд

нөлөөлөх боломжийг өгдөг, улмаар авторитар дэглэмд хүргэх аюултай байдаг нь Сингапур, Сенегал улсуудын жишээн дээрээс харагддаг юм. Тухайлбал, Сингапурт эрх баригч Ардын үйл ажиллагааны нам нь сөрөг хүчнийг дэмждэг сонгогч олонтой тойргийг хувааж эрх баригч намын дэмжигч ихтэй тойрогтой нэгтгэж уг тойрог дахь бүх мандатыг авах маягаар парламентын суудлын 90%-ийг дангаараа авах явдал сүүлийн хэдэн жилд байнга давтагдаж байгаа юм. [Сайн засаглал,2002:33] Ийнхүү сонгуулийг зохион явуулахдаа манипуляци хийх боломж өндөртэй учраас судлаачид томсгосон тойрог бүхий олонхийн системийн үед үүсдэг улс төрийн нөхцөл байдлыг “тогтворт байдал” гэхээс илүү дарангуйлал гэж үздэг байна. Эдгээр нөхцөл байдлаас үзэхэд ардчилалд шилжин орж, улс төрийн тогтвортой либераль дэглэм төлөвшүүлэхийг зорьж буй манай улсын хувьд томсгосон тойрог бүхий олонхийн системийг нутагшуулах шаардлагагүй юм.

5. Сонгогчдын төлөөллийг хэрхэн хангадаг эсэхээр нь ОД системийн хувилбаруудыг авч үзье.

Сонгогчдын өгсөн санал тэр хэмжээгээрээ парламентад тусдаггүй нь ОД системийн гол дутагдал гэж шүүмжлэгчид үздэг.

Ялангуяа нэг мандаттай болон олон мандаттай, 2 шаттай дийлэнхийн систем нь сонгогчдын санал гээгдэх боломжт ихтэй юм. Гэвч сонгогчдын санал бүр парламентад заавал төлөөлөгдөх албатай юу, сонгогчдын саналыг хамгийн сайн төлөөлсөн парламент л үр ашигтай аж илладаг уу гэсэн эргэлзээтэй асуулт төрж байгаа юм.

ОД системийг дэмжигчид санал бүр заавал төлөөлөгдөх албагүй. Ардчилал бол өөрөө олонхийн зарчим дээр үндэслэдэг учраас сонгогчдын олонхийн санал л парламентад орж бодитой суудал болох ёстой гэж үздэг юм.

Мөн сонгогч бүрийн санал парламентад тусч суудал хувирснаар тэр хэмжээгээр улс төрийн тогтолцооны үр ашиг дээшлэхгүй гэж үзэх явдал бий. Сонгогчид тэр бүр зохистой сонголт хийж чаддаггүй, бусдыг даган

дуурайх, популист маягийн амлалтуудад итгэх зэргээр сэтгэл хөдлөлийн үндсэн дээр сонголт хийх нь олонтаа учраас сонгогчдын өгсөн санал бүр парламентад туссанаар эрээвэр, хураавар, хүмүүсийн хүлээлтэд нийцүүлсэн бодлого явуулах гэсэн нам, улстөрчдийн тоо өсөх хандлагатай гэж судлаач Ф. Хермес үзсэн байдаг. []

Энэ системийн дөрвөн хувилбараас сонгогчдын саналыг гээдэггүй, төлөөлж чаддаг тогтолцоо нь өмнө дурьдсанчлан Австрали, Науру хоёрт хэрэглэдэг альтернатив саналын дийлэнхийн систем юм. Энэ тогтолцоонд нэг тойрог, нэг мандатын зарчим үйлчилдэг. Сонгогч хоёр санал өгөх боломжтой байдаг. Түүний эхний санал нь хамгийн их буюу түрүүнд дэмжиж буй нэр дэвшигчид өгөх санал болдог. Нэр дэвшигч 50%+1 санал авч байж ялсанд тооцогдоно. Саналыг тоолохдоо эхний саналын дүн 50%+1-д хүрч байвал шууд ялах бөгөөд хүрэхгүй бол хоёр дахь саналын тоог харгалзан хоёр саналын нийлбэрээс хамгийн их санал авсан нь ялна.

6. Сонгогчдод хэр ойлгомжтой хялбар байхын хувьд системүүдийг авч үзье.

Хүмүүст ойлгогдоход хамгийн хялбар, энгийн систем бол 1 мандаттай харьцангуй олонхийн систем гэж судлаачид үздэг. Энэ тогтолцооны үед санал өгөх, санал тоолох, сонгуулийн дүн гаргах, ялагчийг тодорхойлох зэрэг нь маш ойлгомжтой энгийн байдаг. Сонгогчид нэр дэвшигчдийн жагсаалтаас өөрийн сонгож буй хүнийг онцлон тэмдэглэж, энэ нь саналыг тоолох ажиллагааг ч энгийн хялбар болгодог. Гэтэл бусад 3 хувилбарын хувьд сонгогчид сонголт хийх, сонгогчдын саналыг тоолох, дүнг гаргах нь нэлээд төвөгтэй, зарим тохиолдолд сонгогчдод ойлгомжгүй байдаг. Ялангуяа альтернатив саналын болон олон мандаттай олонхийн системийн хувилбарт энэ байдал их ажиглагддаг.

6. Сонгуулийн өртөг зардлын хувьд ОД системийн хувилбаруудыг харьцуулан үзье.

Хоёр шаттай систем болон альтернатив системийг хэрэглэх үед хоёр дахь шатны сонгууль явуулах нь зардлыг үлэмж өсгөдөг. Сонгуулийн үйл явцыг нарийн төвөгтэй болгон сунжруулахаас гадна сонгогчдод тавих шаардлагыг өндөржүүлж бүхэлдээ сонгуулийн өртөг зардлыг

нэмэгдүүлдэг байна. Энэ нь зөвхөн хоёр дахь шатны сонгууль явуулахтай уялдан гардаг шууд зардалтай төдийгүй сонгуулийн үйл явц сунжирснаас сонгогч, улс төрийн намууд, нэр дэвшигчид, хэвлэл мэдээлэл зэрэг сонгуульд оролцогч бүх талын шууд бус зардал өсдөгтэй холбоотой юм. УИХ-ын 1992,1996,2000,2004 оны сонгуулиудын дүнгээс үзэхэд нийт гишүүдийн 60-65 хувь нь 50-иас дээш хувийн саналаар сонгогдож байв. Үүнээс үзэхэд хэрэв бид хоёр шаттай тогтолцоогоор сонгууль явуулбал нийт тойргуудын 30-40 хувьд мөн дахин сонгууль явагдах болно. Энэ нь сонгуулийн зардлыг мөн төдий хэмжээгээр өсгөх болно.

7. Сонгогчдын идэвх, оролцоонд хэрхэн нөлөөлөх вэ.

Сонгуулийн тогтолцооноос шууд хамааралтайгаар сонгогчдын идэвх оролцоо буурах, эсвэл ихсэн хандлага төдийлөн ажиглагддаггүй. Гэхдээ улс орнуудын сонгуулийн системийн харьцуулсан судалгаануудаас харахад ОД системийн хувилбаруудаас нэг мандаттай олонхийн ба олон мандаттай олонхийн системийн үед сонгогчдын оролцоо хамгийн өндөр түвшинд байдаг байна. Учир нь эдгээр системийн үед сонгуулийн бүх үйл явц энгийн, иргэдэд ойлгомжтой байдаг учраас сонгогчдын сонголтыг их хялбар болгодог ажээ. Харин альтернатив болон хоёр шаттай дийлэнхийн системүүд нь сонгогчдыг хоёр удаа санал өгөхөд хүргэдэг учраас хоёр дахь шатанд идэвхийг бууруулах хандлагатай байдаг байна.

Дүгнэлт

Бид ОД системийн дөрвөн үндсэн хувилбаруудыг тодорхой шалгуур тавин харьцуулж үзэхэд өнөөгийн Монголын улс төрийн тогтолцоо, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хамгийн илүүтэй хангаж буй нь First Past The Post буюу нэг мандаттай харьцангуй олонхийн систем болох нь ажиглагдлаа. Тиймээс УИХ-ын өнөөгийн сонгуулийг одоогийн буюу нэг мандаттай олонхийн системээр явуулах, ингэхдээ өмнөх сонгуулиудаар илэрч байсан хүндрэл, бэрхшээл, сул талуудыг засан сайжруулж хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй хувилбар гэж үзэж байна.

Сонгуулийн энэ тогтолцоог сонгож авснаас үүсэх улс төрийн нөхцөл байдлыг бид дараах байдлаар тооцоолж байгаа юм. Үүнд:

- Сонгуулийн эн тэргүүний үүрэг, зорилт нь улс орны доторхи улс төрийн хүчний харьцаанд нийцсэн бүрэлдэхүүнтэй төлөөлөх байгууллагыг сонгоход биш, харин олонхийн дэмжлэг хүлээсэн чадвартай засгийн газар бүрдүүлэхэд оршино гэсэн байр сууринаас үзвэл нэг мандаттай харьцангуй олонхийг төлөөлсөн систем л энэ үүргийг хангаж чадах юм. Сонгуулийн хувь тэнцүүлэх системийг сонгож авсан тохиолдолд УИХ дахь намуудын тоо нэмэгдэхийн хэрээр ашиг сонирхлын бүлгүүдийн зүгээс төрийн бодлогод үзүүлэх сөрөг нөлөөлөл тэр хэмжээгээр нэмэгдэх болно. Улмаар гүйцэтгэх засаглалын тогтворт байдал алдагдахад хүрч болох юм. Тиймээс улс орон даяар хүчний төвлөрөл бий болгож, эсрэг тэсрэг ашиг сонирхлуудыг нэгтгэн харьцангуй төвийг сахисан хоёр хүчнийг бүрдүүлдэг нэг мандаттай олонхийн систем илүү үр ашигтай байна.

- Намууд эвсэн нэгдэх, задрах, шинэ нам үүсэх гэх мэтээр Монголын улс төрийн намуудын төлөвших процесс дуусаагүй байгаа одоогийн нөхцөлд хувь тэнцүүлэх тогтолцоог хэрэглэх нь улс төрийн тогтворт байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл УИХ-д харьцангуй олон намууд суудал авч, ингэхдээ эвслийн засгийн газар байгуулагдах нөхцөл бүрдэнэ. Үндсэн хуулинд эвслийн засгийн газрын талаарх зохицуулалтын механизм байхгүй учраас бэрхшээл, мухардалд хүрч болзошгүй юм. Нөгөө талаас ОД нь Монгол улсад хоёр буюу гурван намын тогтолцоо хэлбэршин төлөвших эхлэлийг нэгэнт тавьсан бөгөөд энэ хандлагыг таслан зогсоох нь улс төрийн намуудын төлөвшилд сөргөөр нөлөөлж намууд задрах, шинэ жижиг намууд олноор төрөн гарах магадлал ихтэй юм. Тиймээс улс төрийн тогтворт байдал, төлөвшин буй намын системийг хадгалахын тулд өнөөгийн сонгуулийн тогтолцоогоо бүрэн солих бус, харин боловсронгуй болгох нь илүү үр дүнтэй, эрсдэл багатай юм.
- ОД системээр сонгууль явагдахад эрх баригч намын үйл ажиллагаанд хяналт тавих хүчтэй сөрөг хүчин бүрдэх боломж илүү байдаг нь АНУ, Их Британи гэх мэт ардчилал өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас харагдаж байна. Харин бусад систем нь эвслийн засгийн газрууд бүрдүүлдэг тул хариуцлага тооцох боломж багатай юм.

- Монголын сонгогчид улс төрийн намыг нэр дэвшигчээр нь төсөөлж үнэлж, саналаа өгч ирсэн дадал, уламжлалд өнөөгийн тогтолцоо ихэд нийцдаг юм. Энэ парламентын гишүүн болон түүний сонгогдсон тойргийн сонгогчдын хооронд тогтвортой холбоо, хариуцлагын тогтолцоог бий болгодог. Энэ тогтолцооны үед парламентын гишүүн нь зөвхөн улс төрийн намыг төлөөлөх бус харин өөрийн сонгогдсон тойргийн иргэдийг мөн төлөөлөх болдог. Тухайн гишүүн аль нэгэн тойргоос сонгогдохын тулд тэр тойргийн иргэдийн эрх ашиг, шаардлагыг парламентад уламжлах, хэрэгжүүлэх хариуцлага хүлээдэгт сонгогчид дуртай байдаг юм. Бид гишүүн-сонгогчийн ийм тогтвортой холбоо хамаарал нь эдийн засагт хөдөө аж ахуй давамгайлсан болон хөгжиж буй улс орнуудад чухал ач холбогдолтой гэж судлаачдын үздэгийг анхаарууштай.
- Олон түмэнд танигдсан бие даан нэр дэвшигчид сонгогдох боломж бусад тогтолцоотой харьцуулахад харьцангуй өндөр байдаг буюу зөвхөн намд төвлөрсөн улс төрийн тогтолцоог даван туулах боломжийг хувь хүмүүст олгодог. Сонгогчийн зүгээс аль нэгэн намын үзэл баримтлалыг бүхэлд нь хүлээж авах албагүй бөгөөд хувь хүний ертөнцийг үзэх үзэл бодлоос ухрахгүйгээр ерөнхийдөө амжилтанд хүрэх боломжтой нэр дэвшигчээс чухамхүү тухайн үед сонгогчийн хувьд хойшлуулашгүй чухалд тооцож буй асуудлыг шийдвэрлэхээр амлаж буй хүнд саналаа өгдөг. Ийм онцлог бүхий нэг мандаттай олонхийн систем өнөөгийн Монголын сонгогчдод нэгэнт ижил дасал болсон “ нутагшсан” систем юм.
- Улс орнуудын практикаас харахад ОД системийг холимог юмуу хувь тэнцүүлэх хувилбар руу өөрчлөх бодит боломжтой байдаг. Харин нэгэнт хувь тэнцүүлэх системийг сонгосон тохиолдолд эргэж ОД систем рүү шилжих улс төрийн боломж байдаггүй ажээ. Учир нь сонгуулийн системийн энэ өөрчлөлт нь парламент дахь улс төрийн намуудын хүчний харьцааг эрс өөрчлөхөд хүргэдэг тул эргэж ОД систем руу шилжих гэсэн оролдлого батлагдахгүй өнгөрдөг нь ӨАБНУ-ын түүхээс харагддаг. 1990 онд Н. Мандела шоронгоос суллагдан улс төрийн амьдралд буцаж орсныхоо дараа цагаан арьст давамгайлсан парламентад хар арьстан

сонгогчдын төлөөллийг оруулах үүднээс хувь тэнцүүлэх системийг идэвхийлэн дэмжсэний хүчинд 1994 оны сонгуулийг энэ системээр явуулахаар болгосон юм. Гэвч энэ сонгуулийн үр дүнд хар арьстнууд болон эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдсэн хэдий ч парламентад арьсны үзлийг дэмжигч харгис намууд, коммунистууд, лалын шашны тулгуур үзэлтнүүд, жижиг угсаатны намууд гэх мэт ашиг сонирхлын ихээхэн зөрөө бүхий олон янзын хүчнүүд орж ирснээр харьцангуй тогтвортой байсан улс төрийн нөхцөл байдал хурцадсан юм.

- Сонгогчдын улс төрийн сонирхлыг сэргээж идэвхийг нь өрнүүлдэг. Нэг мандаттай олонхийн тогтолцоо нь сонгогчдод энгийн ойлгомжтой учраас сонгууль болж өнгөрсний дараа сонгуулийн үр дүнд эргэлзэх, төөрөлдөх зүйл гардаггүйгээрээ бусад хувилбаруудаас давуу талтай байна. Ихэнх сонгогчид сонгуулийн дүн хэрхэн гарах, хэнийг ялагч гэж тооцохыг мэдэж байдаг тул тэдний зүгээс сонголтоо хийхэд дөхөмтэй байдаг. Нөгөө талаас энэ систем нь “спортын” тэмцээний адил тойрог бүр дээр ширүүн өрсөлдөөнтэй явагддаг учраас сонгогчдын улс төрийн сонирхлыг сэргээж идэвхийг нь өрнүүлдэг. Ингэснээрээ сонгуулийн дараа шинээр бүрдсэн засгийн газарт тавих сонгогчдын хяналтыг сайжруулдаг байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Сонгуулийн тогтолцоо, түүний тархалт

	Уг системийг хэрэглэж буй улсын тоо	%	Хүн ам (саяаар)	%	Либераль ардчилсан дэглэм бүхий	%	Хүн ам (саяаар)	%	“Чөлөөт” дэглэм бүхий	%	“Чөлөөт бус” дэглэм бүхий	%
НМО	70	33	1,850	45	11	30	1,273	71	35	36	17	37
ОМ	10	5	139	3	1	3	1	0.1	3	3	3	6
АС	2	1	18	0.4	1	3	18	1	2	2	0	-
ХШ	31	15	427	10	1	3	58	3	7	7	11	24
Параллел	20	9	443	11	1	3	126	7	5	5	5	11
ҮШНС	2	1	5	0.1	0	-	-	-	1	1	0	-
ЦП	67	32	968	23	15	42	158	9	39	40	10	22
ХСП	7	3	265	6	4	11	162	9	4	4	0	-
ШНСП	2	1	4	0.1	2	6	4	0.2	2	2	0	-
	211		4,119		36		1,800		98		46	

Тайлбар:

НМО – Нэг мандаттай олонхийн систем

ОМ – Олон мандаттай олонхийн систем

АС – Альтернатив саналын дийлэнхийн систем

ХШ – Хоёр шаттай дийлэнхийн систем

Параллел – Парламентын суудлын 50% нь 1 мандаттай олонхиор,

50% нь хувь тэнцүүлж бүрддэг холимог систем

ҮШНС -- Үл шилжих нэг саналын хувь тэнцүүлсэн систем

ЦП – Цэвэр пропорциональ систем

ХСП – Хоёр саналын пропорциональ систем

ШНСП – Шилжих нэг саналын пропорциональ систем

Хавсралт 2. Сонгуулийн тогтолцоо, түүний бус нутгууд дахь тархалт

	<i>Африк</i>	<i>Америк</i>	<i>Ази</i>	<i>Пост коммунист улсууд</i>	<i>Баруун Европ</i>	<i>Ойрхи Дорнод</i>	<i>Далайн орнууд</i>	<i>Нийт</i>
НМО	19 (35%)	19 (40%)	10 (45%)	1 (4%)	4 (14%)	3 (30%)	14 (64%)	70
ОМ	1 (2%)	2 (4%)	5 (23%)	0	0	2 (20%)	0	10
АС	0	0	0	0	0	0	2 (9%)	2
ХШ	10 (18%)	6 (12%)	1 (5%)	8 (30%)	2 (7%)	2 (20%)	2 (9%)	31
Параллел	0	0	0	0	0	1 (10%)	1 (4%)	2
ҮШНС	7 (13%)	2 (4%)	3 (15%)	7 (26%)	1 (3%)	0	0	20
ЦП	17 (31%)	16 (33%)	3 (15%)	10 (37%)	17 (61%)	2 (20%)	2 (9%)	67
хсп	0	3 (6%)	0	1 (4%)	2 (7%)	0	1 (4%)	7
ШНСП	0	0	0	0	2 (7%)	0	0	2
НИЙТ	54	48	22	27	28	10	22	211

Хавсралт 3. Дэлхийн улсуудын сонгуулийн систем

Улсууд	Сонгуулийн систем	Парламентын гишүүдийн тоо
Австрали	Олон мандаттай олонхийн систем	148
Австри	Цэвэр пропорциональ	183
Азербайджан	Хоёр санал бүхий холимог	125
Алжир	Цэвэр пропорциональ	430
Албани	Хоёр санал бүхий холимог	140
Америкийн Самоа	Нэг мандаттай харьцангуй олонхи	20
АНУ	Нэг мандаттай харьцангуй олонхи	435
Андорра	Параллель пропорциональ	28
Ангол	Цэвэр пропорциональ	220
Антигуа Барбуда	Нэг мандаттай харьцангуй олонхи	17
Арабын НЭУ	Нэг мандаттай харьцангуй олонхи	
Аргентин	Цэвэр пропорциональ	257
Армен	Хоёр санал бүхий холимог	189
Афганистан	Нэг мандаттай харьцангуй олонхи	205
Бангладеш	Нэг мандаттай харьцангуй олонхи	300
Бахрейн	Альтернатив саналын систем	30
Барбадос	Нэг мандаттай харьцангуй олонхи	28
Белорус	Хоёр шаттай дийлэнхи	260
Белиз	Нэг мандаттай харьцангуй олонхи	29
Бенин	Цэвэр пропорциональ	83
Бирм	Нэг мандаттай харьцангуй олонхи	485
Болив	Хоёр санал бүхий холимог	130
Болгар	Цэвэр пропорциональ	240
Босни-Герцоговин	Цэвэр пропорциональ	240
Ботсвана	Нэг мандаттай харьцангуй олонхи	47
Бразил	Цэвэр пропорциональ	513
Бурунди	Цэвэр пропорциональ	81
Буркина Фасо	Цэвэр пропорциональ	111
Венесуэл	Хоёр санал бүхий холимог	203

Вьетнам	Хоёр шаттай дийлэнхи	393
Габон	Хоёр шаттай дийлэнхи	120
Гамби	Нэг мандаттай харьцангуй олонхи	36
Гана	Нэг мандаттай харьцангуй олонхи	200
Герман	Хоёр санал бүхий холимог	656
Гвиней	Хоёр санал бүхий холимог	114
Гвиней-Биссао	Цэвэр пропорциональ	100
Гвиана	Цэвэр пропорциональ	53
Гренада	Нэг мандаттай харьцангуй олонхи	15
Гватемал	Параллель пропорциональ	80
Гондурас	Цэвэр пропорциональ	128
Грек	Цэвэр пропорциональ	300
Гүрж	Нэг мандаттай харьцангуй олонхи	33
Дани	Цэвэр пропорциональ	179
Доминик	Нэг мандаттай харьцангуй олонхи	31
Доминиканы БНУ	Цэвэр пропорциональ	120
Жибути	Альтернатив саналын систем	65
Египт	Хоёр шаттай дийлэнхи	444
Замби	Нэг мандаттай харьцангуй олонхи	150
Зааны ясан эрэг	Нэг мандаттай харьцангуй олонхи	25
Зимбабве	Нэг мандаттай харьцангуй олонхи	120
Израиль	Цэвэр пропорциональ	120
Индонези	Цэвэр пропорциональ	425
Иордан	Шилжих нэг санал бүхий пропорциональ	80
Ирак	Хоёр шаттай дийлэнхи	250
Иран	Хоёр шаттай дийлэнхи	270
Ирланд	Шилжих нэг санал бүхий пропорциональ	166
Исланд	Цэвэр пропорциональ	24
Испани	Цэвэр пропорциональ	350
Итали	Хоёр санал бүхий холимог	630
Их Британи	Нэг мандаттай харьцангуй олонхи	659
Казакстан	Нэг мандаттай харьцангуй олонхи	67
Камбож	Цэвэр пропорциональ	120

Камерун	Хоёр санал бүхий холимог	180
Кабо Верде	Цэвэр пропорциональ	79
Канад	Нэг мандаттай харьцангуй олонхи	295
Катар	Чөлөөт ардчилсан сонгуульгүй	
Кени	Нэг мандаттай харьцангуй олонхи	188
Киргиз	Хоёр шаттай дийлэнхи	35
Колумби	Цэвэр пропорциональ	168
Комор	Хоёр шаттай дийлэнхи	42
Конго	Хоёр шаттай дийлэнхи	125
Коста Рика	Цэвэр пропорциональ	57
Куба	Чөлөөт ардчилсан сонгуульгүй	589
Кувейт	Олон мандаттай олонхийн систем	50
Лаос	Олон мандаттай олонхийн систем	85
Латви	Цэвэр пропорциональ	100
Лесото	Нэг мандаттай харьцангуй олонхи	65
Либериа	Цэвэр пропорциональ	64
Лихтенштейн	Цэвэр пропорциональ	25
Люксембург	Цэвэр пропорциональ	60
Малави	Нэг мандаттай харьцангуй олонхи	177
Мадагаскар	Цэвэр пропорциональ	138
Малайз	Нэг мандаттай харьцангуй олонхи	192
Малдив	Олон мандаттай олонхийн систем	40
Македони	Хоёр шаттай дийлэнхи	120
Маршалын арлууд	Нэг мандаттай харьцангуй олонхи	33
Мальт	Шилжих нэг санал бүхий пропорциональ	65
Мексик	Хоёр санал бүхий холимог	500
Молдав	Хоёр шаттай дийлэнхи	104
Монако	Хоёр шаттай дийлэнхи	18
Марокко	Нэг мандаттай харьцангуй олонхи	222
Мозамбик	Цэвэр пропорциональ	250
Монгол	Нэг мандаттай харьцангуй олонхи	76
Намиби	Цэвэр пропорциональ	72
Науру	Альтернатив	18

Нидерланд	Цэвэр пропорциональ	150
Никирагуа	Цэвэр пропорциональ	92
Нигери	Параллель пропорциональ	83
Норвеги	Цэвэр пропорциональ	165
Оман	Чөлөөт ардчилсан сонгуульгүй	
ОХУ	Параллель пропорциональ	450
ӨАБНУ	Цэвэр пропорциональ	400
Пакистан	Нэг мандаттай харьцангуй олонхи	217
Палестин	Олон мандаттай олонхийн систем	88
Панам	Цэвэр пропорциональ	72
Парагвай	Цэвэр пропорциональ	80
Перу	Цэвэр пропорциональ	120
Польш	Цэвэр пропорциональ	460
Португали	Цэвэр пропорциональ	230
Румын	Цэвэр пропорциональ	328
Сан Марино	Цэвэр пропорциональ	70
Самао	Цэвэр пропорциональ	50
Саудын Араб	Чөлөөт ардчилсан сонгуульгүй	
Свазиленд	Цэвэр пропорциональ	55
Сенегал	Олон мандаттай олонхийн систем	120
Серб	Нэг мандаттай харьцангуй олонхи	33
Сири	Цэвэр пропорциональ	68
Сингапур	Олон мандаттай олонхийн систем	83
Словак	Цэвэр пропорциональ	150
Словени	Цэвэр пропорциональ	90
Соломоны аралууд	Нэг мандаттай харьцангуй олонхи	47
Сомали	Параллель пропорциональ	123
Судан	Нэг мандаттай харьцангуй олонхи	275
Суринами	Цэвэр пропорциональ	51
Тайвань	Параллель пропорциональ	164
Тайланд	Хоёр шаттай дийлэнхи	181
Того	Хоёр шаттай дийлэнхи	81
Тонга	Нэг мандаттай харьцангуй олонхи	9
Тринидад ба Того	Нэг мандаттай харьцангуй олонхи	36
Туркменстан	Хоёр шаттай дийлэнхи	163

Турк	Цэвэр пропорциональ	550
Тунис	Параллель пропорциональ	50
Узбекистан	Хоёр шаттай дийлэнхи	250
Украин	Хоёр шаттай дийлэнхи	450
Уругвай	Цэвэр пропорциональ	99
Фижи	Олон мандаттай олонхийн систем	70
Финлянд	Цэвэр пропорциональ	200
Филиппин	Олон мандаттай олонхийн систем	204
Франц	Хоёр шаттай дийлэнхи	577
Францын Гвиней	Хоёр шаттай дийлэнхи	19
Швед	Цэвэр пропорциональ	349
Швейцарь	Цэвэр пропорциональ	200
Шинэ Зеланд	Цэвэр пропорциональ	120
Шри-Ланка	Цэвэр пропорциональ	225
Чех	Цэвэр пропорциональ	200
Чили	Цэвэр пропорциональ	120
Эквадор	Хоёр санал бүхий холимог	77
Эль Салвадор	Цэвэр пропорциональ	84
Экваторын Гвиней	Цэвэр пропорциональ	80
Энэтхэг	Нэг мандаттай харьцангуй олонхи	543
Эстони	Цэвэр пропорциональ	101
Этиопи	Нэг мандаттай харьцангуй олонхи	547
Ямайка	Нэг мандаттай харьцангуй олонхи	60
Япон	Параллель пропорциональ	500

Хавсралт 4. Дөрвөн хувилбар – найман шалгуур

Шалгуур	Нэг мандаттай олонхийн хувилбар (НМО)	Олон мандаттай томсгосон тойрог бүхий олонхийн хувилбар (ОМ)	Хоёр дахь буюу альтернатив санал гаргах эрх бүхий хувилбар (АС)	Хоёр шаттай хувилбар (ХШ)
Дэлхийн улсуудад хэрэглэгдэх хүрээ	С	Д	М	Д
Улс төрийн дэглэмийн шинж чанарт эерэгээр нөлөөлөх	С	Д	Д	М
Улс төрийн намын системд хэрхэн эерэгээр нөлөөлөх	Д	Д	С	Д
Улс төрийн системийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөх	С	Д	С	С
Сонгогчдын төлөөллийг хэрхэн тусгах	М	Д	С	Д
Сонгогчдод хэр ойлгомжтой хялбар байх	С	Д	М	Д
Сонгуулийг уг хувилбараар явуулахад өртөг	С	Д	Д	М

зардал багатай байдал				
Сонгогчдын идэвх, оролцоонд хэрхэн нөлөөлөх	Д	Д	Д	М
	5С+2Д+1М	8Д	3С+3Д+2М	1С+4Д+3М

Тайлбар: С – сайн
Д – дунд
М – муу

Хавсралт 5.

IDEA-ийн ангиллаар сүүлийн 20 жил чөлөөт сонгууль хийж ирсэн тогтвортой ардчилсан гэж тооцогддог 36 улс

Австри	Ирланд	Норвеги
Австрали	Израиль	Португаль
АНУ	Испани	Папуа Шинэ Гвиней
Багам	Итали	Тринадад ба Тобаго
Барбадос	Их Британи	Финлянд
Бельги	Канад	Франц
Ботсван	Колумби	Шинэ Зеланд
Венесуэль	Коста Рика	Швед
ХБНГУ	Люксембург	Щвейцарь
Грек	Мальта	Энэтхэг
Дани	Мавритани	Ямайка
Исланд	Нидерланд	Япон

Лавлагаа

- Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлын судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл. 2003. УБ.
- Алмонд Габриэл, Бенгмэн Пауэл. 2002. *Сравнительная политология сегодня*. Москва:
- Andrew Reynolds, Ben Reilly. 1997. *The International IDEA Handbook of Electoral Systems Design*. Stockholm
- Comparative Politics: *Annual Editions*. 1998/1999. Connecticut: Dushkin Publishing
- Institute for Democracy and Electoral Assistance. Website: <http://www.int-idea.se>
- Lijphart Arendt. 1995. *Electoral Systems and Party Systems*. Washington DC: Congressional Quarterly Press
- Mahler Gregory S, Donald J. Macinis. 2002. *Comparative Politics*. Toronto: Pearson Education
- Монгол Улсын Их Хурал. 2003. *Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр*.
- Lawrence LeDuc (ed.) 1996. *Comparing Democracies: Elections and Voting in Global Perspective*. London: Sage
- “Сайн засаглал”. Олон улсын бага хурлын эмхэтгэл. 2002. УБ.
- Сонгогчдын Боловсрол Төв. 2004. *УИХ-ын сонгуулийн хуулийн үзэл баримтлал*. <http://www.forum.mn> сайтаас 2004.11.15-нд үзэв.
- Schroeder Richard. 1999. *An Outline of American Government*. US Information Agency.
- Чилкот Рональд Х. 1997. *Теория сравнительной политологии*. Москва
- Эндрейэ Чарльз, Ф. 2000. *Сравнительный анализ политических систем*. Москва